



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 1306

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/532 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нуклон” ХХК-тай байгуулсан “Баянзүрх дүүрэгт хог тээврийн автомашин нийлүүлэх” БЗДХААА-19/117 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй 2 ширхэг автомашиныг нийслэлийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх автомашинуудыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Ажлыг хэсэг /М.Энхболд/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 08 дүгээр сарын 28 өдрийн 1306 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Мөнхбаатар	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын мэргэжилтэн
	Г.Ядамдорж	Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар дөрөв” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер
	Д.Бадамцэцэг	Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын хөрөнгийн нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Б.Мөнгөнхүү	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн